

**“МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН 2024 ОНЫ  
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

|   |  |                                     |                                 |
|---|--|-------------------------------------|---------------------------------|
| <i>Хагас жил, улирлын үйл ажиллагааны тайлан /маягт 2/</i>  |  |                                     |                                 |
| <i>Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайланг дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.</i> |  |                                     |                                 |
| <i>Тайлагнах хугацаа</i>  | 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс<br>2024 оны 06 дугаар сарын 30-ны өдөр  |                                     |                                 |
| <i>Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар</i>   | Нэр: “Монгол шуудан” ХК<br>УБГД: 9012001026<br>ҮЦК: MNP, MN00MNP05412<br>Утас: (+976) 7007-8918, (+976) 11-330788<br>Хаяг: Сүхбаатарын талбай1, Энхтайвны өргөн чөлөө, Чингэлтэй дүүргийн 1-р хороо, Улаанбаатар хот-15160, Монгол Улс |                                     |                                 |
| <i>Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр</i>   | Монголын хөрөнгийн бирж  |                                     |                                 |
| <i>Бизнесийн үйл ажиллагааны салбар</i>   | Шуудан, зарлага, элчийн үйл ажиллагаа  |                                     |                                 |
| <i>Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг</i>  | 99,586,363   |                                     |                                 |
| <i>Хагас жил, улирлын тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр</i>  | Улирлын тайланг бэлтгэсэн:<br>ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Д.Цэцгээ<br><br>Хянасан:<br>Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн  |                                     |                                 |
| <b>1.</b>   | <i>Хагас жил болон улирлын санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/</i>  |                                     |                                 |
| <i>Санхүүгийн байдлын үзүүлэлт</i>  | Үзүүлэлт   | Эхний үлдэгдэл<br>(2024.01.01)      | Эцсийн үлдэгдэл<br>(2024.06.30) |
|   | <b>ХӨРӨНГӨ</b>   |                                     |                                 |
|   | Эргэлтийн хөрөнгө  | 27,634,879,517.26                   | 26,579,614,609.82               |
|   | Эргэлтийн бус хөрөнгө  | 10,806,095,264.30                   | 10,987,564,559.80               |
|   | <b>Нийт хөрөнгө</b>  | <b>38,439,974,781.56</b>            | <b>37,567,179,169.62</b>        |
|   | <b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>   |                                     |                                 |
|   | Өр төлбөрийн нийт дүн  | 12,292,598,303.11                   | 11,687,822,392.97               |
|   | Эздийн өмч   | 26,147,376,478.45                   | 25,879,356,776.65               |
|   | <b>Нийт өр төлбөр ба эздийн өмч</b>  | <b>38,439,974,781.56</b>            | <b>37,567,179,169.62</b>        |
| <i>Орлогын тайлан</i>   | Үзүүлэлт   | Өмнөх оны гүйцэтгэл<br>(2023.06.30) | Эцсийн үлдэгдэл<br>(2024.06.30) |
|   | <b>Борлуулалтын орлого (цэвэр)</b>   | <b>9,559,869,763.03</b>             | <b>11,614,948,426.41</b>        |
|   | Борлуулалтын өртөг   | 10,527,788,269.20                   | 10,642,554,854.82               |
|   | Үндсэн бус үйл ажиллагааны орлого  | 2,284,357,569.10                    | 264,401,093.23                  |
|   | Үндсэн бус үйл ажиллагааны зардал  | 763,641,540.98                      | 490,440,323.93                  |
|   | Бусад  | 43,872,394.55                       | 98,072,823.02                   |
|   | <b>Татвар төлөхийн өмнөх ашиг</b>  | <b>508,925,127.40</b>               | <b>39,890,558.73</b>            |
|   | <b>Орлогын татварын зардал</b>   | <b>28,684,393.81</b>                | <b>17,370,538.58</b>            |
|   | <b>Татварын дараах ашиг</b>  | <b>480,240,733.59</b>               | <b>22,520,020.15</b>            |
| <i>Өмчийн өөрчлөлтийн тайлан</i>  | Үзүүлэлт   | Эхний үлдэгдэл<br>(2024.01.01)      | Эцсийн үлдэгдэл<br>(2024.06.30) |
|   | <b>Эздийн өмч</b>  | <b>9,958,636,300.00</b>             | <b>9,958,636,300.00</b>         |
|   | <b>Хуримтлагдсан ашиг</b>  | <b>6,266,231,638.40</b>             | <b>6,288,751,658.55</b>         |

|     | Мөнгөн гүйлгээний тайлан   | Үзүүлэлт   | Эхний үлдэгдэл<br>(2024.01.01) | Эцсийн үлдэгдэл<br>(2024.06.30) |
|-----|--|--|--------------------------------|---------------------------------|
|     |  | Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн   | 1,098,459,797.85               | -549,507,137.67                 |
|     |  | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ                                    | -153,514,536.70                | -561,437,230.65                 |
|     |  | Бүх цэвэр мөнгөн гүйлгээ   | 1,286,869,032.85               | -3,587,970,196.66               |
| 2.  | Хагас жил болон улирлын санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт   |  |                                |                                 |
| 3.  | Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинжилгээ, орлого, зарлага, ашигийн үзүүлэлтүүийг тооцож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт   |  |                                |                                 |
| 3.1 | Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/  | Цэвэр ашгийн хувь - 0.2%<br>Өөрийн хөрөнгийн өгөөж - 0.22%<br>Нийт хөрөнгийн өгөөж - 0.06% |                                |                                 |
| 3.2 | Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт  | Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа 1.1  |                                |                                 |
| 3.3 | Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчны нөлөөлөл, бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл хэлбэрт гарч буй өөрчлөлт, дээрх өөрчлөлтөд компанийн зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний мэдээлэл   | Өөрчлөлт байхгүй.  |                                |                                 |
| 3.4 | Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлого   | Санхүүгийн тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй.                             |                                |                                 |
| 4.  | Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийгдэх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/   |  |                                |                                 |
|     | Тайлант хугацаанд сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл хийгдээгүй.  |  |                                |                                 |
| 5.  | Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойших төслийн хэрэгжилтийн явц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан, мэдээ   |  |                                |                                 |
|     | Тайлант хугацаанд Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор олон нийтэд санал болгон хувьцаа гаргаагүй.   |  |                                |                                 |
| 6.  | Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл   |  |                                |                                 |
|     | <p><b>Хувьцаа эзэмшигчдийн хурал</b></p> <p>Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 сарын 29-ний өдрийн 10:00 цагт “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК-ийн хурлын танхим (компанийн төв байрны 4 давхар)-д зохион байгуулж, нийт саналын эрх бүхий 95,533,843 ширхэг хувьцаа буюу 86.7 хувийн хувьцаа эзэмшигчид хуралд оролцож дараах шийдвэрийг гаргалаа.</p> <ol style="list-style-type: none"> <li>Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлав.</li> <li>Компанийн дүрмйн нэмэлт өөрчлөлтийг батлав.</li> <li>ТУЗ-ийн 2024 оны зардлын төсвийг батлав.</li> </ol> <p><b>Хурлын дараах тайлан</b></p> <p>Хуулийн хугацаанд буюу 2024.04.30-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материал (144 хуудас хэвлэмэл материал, компанийн жилийн тайлан болон ХЭ-чдийн хурлын товхимол хэлбэрийн материал)-ыг Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржид хүргүүлсэн.</p> |  |                                |                                 |

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар батлагдсан компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг Санхүүгийн зохицуулах хороо болон Улсын бүртгэлийн ерөнхий газар зэрэг эрх бүхий байгууллагуудаар хянуулан бүртгүүлж, хүчин төгөлдөр байдлыг ханган мөрдөж байна.

**Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн**

1. **Даваахүү НАРАНГЭРЭЛ**  
Ердийн гишүүн, ТУЗ-ийн дарга
2. **Даваасамба ДЭЛГЭРМАА**  
Ердийн гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны дарга
3. **Даваадорж БАЛЖИННЯМ**  
Ердийн гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны гишүүн
4. **Батаа БАТЦЭЦЭГ**  
Ердийн гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны гишүүн
5. **Одончимэд ОДБАЯР**  
Ердийн гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооны дарга
6. **Батбилэг ЗОЛБОО**  
Ердийн гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын болон Нэр дэвшүүлэх хорооны гишүүн
7. **Банзрагч ГАНБААТАР**  
Хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын, Нэр дэвшүүлэх болон Цалин урамшууллын хорооны гишүүн
8. **Дарамбазар БАЛДОРЖ**  
Хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дарга, Нэр дэвшүүлэх болон Цалин урамшууллын хорооны гишүүн
9. **Чүлтэм АМАРБААТАР**  
Хараат бус гишүүн, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын, Нэр дэвшүүлэх болон Цалин урамшууллын хорооны гишүүн

**Удирдлага**

- Тайлант хугацаанд компанийн гүйцэтгэх захирал Б.Анхбаатар өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөв.
- Төлөөлөн удирдах зөвлөл нь КТХ болон холбогдох хууль, дүрэм, журмын дагуу Гүйцэтгэх захирлын сонгон шалгаруулалтыг анх удаа нээлттэй зарлаж, нийт 7 нэр дэвшигчээс боловсрол, ур чадвар, ажлын туршлага зэрэг сонгон шалгаруулалтын шаардлага бүрэн ханган хамгийн өндөр үнэлгээ авсан Гэрэлтийн Тэлмэнг 2024 оны 04 сарын 01-ний өдрөөс компанийн гүйцэтгэх захирлаар томилогдов.
- Компанийн бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн баталсан. Энэ дагуу Бизнес хөгжлийн газрын захирлаар Э.Золзаяаг, Санхүү, төлөвлөлтийг газрын захирлаар Г.Ганчимэг нарыг тус тус томилов.

7. *Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан, мэдээлэл*

**Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын мэдээлэл**

Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит болон ээлжит бус 8 удаагийн хуралдаанаар 26 асуудлыг хэлэлцэж, 14 тогтоол, 5 тэмдэглэлээр шийдвэр гаргасан байна.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт орсноор Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын нэршил өөрчлөгдөж, энэ дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам, хороодын журмыг шинэчлэн боловсруулж батлуулж байна.

**Ногдол ашиг**

“Монгол шуудан” ХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 24/01 дугаар тогтоолоор компанийн 2023 оны цэвэр ашгийн дүнгээс 30.36 хувиар буюу нэгж хувьцаанд 6.0 төгрөгөөр тооцож

ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргасан. СЗХ-ны тогтоолын дагуу 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны хадгаламжийн хансанд шилжүүлэх замаар ногдол ашгийг олгосон. Ногдол ашиг хуваарилалтын тайланг Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржид хугацаанд нь хүргүүлсэн.

### Мэдээллийн ил тод байдлын тайлагнал

Тайлант хугацаанд дараах тайлан мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн бирж рүү илгээн, хуулийн хугацаанд олон нийтэд тайлагнан ажилласан.

- 2023 оны жилийн үйл ажиллагааны тайлан (монгол, англи хэл дээр),
- 2023 оны Аудитлагдсан санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт (монгол, англи хэл дээр),
- 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулсан тайлан материал,
- Тухай бүр илгээх ТУЗ-ийн гишүүдийн болон удирдлагын багийн өөрчлөлтийн мэдээлэл,

8. *Үйл ажиллагаатай холбоотой бусад нэмэлт мэдээлэл*



### АГУУЛТА

- 01 2024 оны эхний хагас жилийн ерөнхий статистик
- 02 2024 оны эхний хагас жилийн онцлох ажлууд
- 03 2024 оны эхний хагас санхүүгийн үзүүлэлт

## ЕРӨНХИЙ СТАТИСТИК

### Ерөнхий мэдээлэл (хагас жил):



### Үндсэн үйл ажиллагаа (хагас жил): Бусад (хагас жил):



3.3 сая шуудан хүргэж, тээвэрлэв



## ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



### ШИНЭ БАРИЛГА АШИГЛАЛТАНД АВЛАА:

- 2020 – 2023 оны хооронд баригдсан барилгыг ашиглалтанд хүлээн авав
- Нийт 5.1 тэрбум төгрөгийн санхүүжилтээр барилгын ажлыг дуусгав
- 2024 оны 6.1-нд ТӨВ ШУУДАН-аас нүүлгэн шилжүүлэлт хийж, үйл ажиллагааг эхлүүлэв



### ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ:

- Компанийн ТУЗ-ийн 2024.02.26 өдрийн шийдвэрээр гүйцэтгэх захирлын нээлттэй сонгон шалгаруулалт АНХ УДАА зарлав
- Сонгон шалгаруулалтад нийт 7 нэр дэвшигч оролцож, 3 үе шаттай зохион байгуулав
- Гүйцэтгэх захирлаар Г.Тэлмэнг сонгон шалгаруулж, 2024.04.01-ээс ажилд томилов



### ОРОН НУТАГ – БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ:

- Аймгуудтай 2024 оны удирдах ажилтны зөвлөгөөн зохион байгуулав
- Аймгуудын 2024 оны төлөвлөгөө, зорилтот түвшинг батлав
- Аймгуудад хүний нөөц, хүний эрхийн тулгамдсан асуудлаар сургалт чиглүүлэг хийв
- Цаашдын зорилго зорилт, төлөвлөгөөг танилцуулж, нэгдсэн зорилготой болов

## ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



### ЧАДАВХИЖУУЛАХ СУРГАЛТ, АРГА ХЭМЖЭЭ:

- ТОП менежерүүдийн сургалт зохион байгуулав
- Компанийн стратеги, төлөвлөгөө хэлэлцэв
- Алдагдал бууруулж, ашиг орлого нэмэгдүүлэх төлөвлөгөө гаргав



### ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХУРАЛ:

- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг амжилттай зохион байгуулав
- Компанийн дүрэмд өөрчлөлт оруулав
- Компанийн 2023 оны үр дүнгийн тайланг ХЭХ-аар дүгнэж баталгаажуулав



### 2024-2027 ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР:

- Компанийн 2024-2027 оны хөгжлийн хөтөлбөр боловсруулж, ТУЗ-еер хэлэлцүүлэв
- Компанийг дүнд хугацаанд 4 стратеги чиглэлээр хөгжүүлэхээр тодорхойлов
- Компанийн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 8.8 сая ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай



## ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



### ГАДААД БИЗНЕС, ХАМТЫН АЖИЛЛАГАА:

- Гадаад хамтын ажиллагааг сэргээх чиглэлээр үүлзалтүүд зохион байгуулах (UPU, APPU, USA, GERMANY, CHINA POST, RUSSIAN POST)
- ДШХ-ны санхүүжилтээр 150 сумыг ПОС төхөөрөмжөөр хангах, цахим үйлчилгээ үзүүлэх төслийг эхлүүлээ
- Хятадын шуудантай онлайн худалдааны барааны хүргэлтийг эхлүүлэх туршилт хийв



### ҮЙЛ АЖИЛЛАГААНД БҮРЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ:

- Мэдээллийн технологи болон боловсон хүчний чадавхийн АУДИТ
- Хөдөлмөр, аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдэлийн үнэлгээ
- Байгууллагын соёлын болон ажилтны сэтгэл ханамжийн судалгаа



### ТҮҮХЭН МАРКУУД ХУДАЛДААНД ГАРЛАА:

- 7 сэдвийн марк худалдаанд нэвтрүүлээ
- ХБНГУ, Швейцарийн холбооны улсын дипломат харилцааны 50 жилийн ойн марк
- Хубилай хааны зарлиг – Монголбанкны 100 жил
- Монгол Улсын Ерөнхий сайд Жалханз хутагт Ц.Дамдинбазар, Улиастайн сайд Дилов хутагт Б.Жамсранжавын нэрэмжит марк
- Монголын анхны марк ЮНЕСКОД бүртгэгдэв

## ОНЦЛОХ ШУУДАН ТЭЭВЭР



БЕГ-аас зарласан “Ерөнхий боловсролын сургуульд сурах бичиг хүргэх тендер”-т шалгарч орон даяар 812 сургуульд 1.8 сая ширхэг сурах бичгийг хүргэлээ.




2024 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тоног төхөөрөмж, саналын хуудсыг орон нутгийн сонгуулийн штабуудад тээвэрлэж хүргэлээ.




ТЕГ, БҮТ-тэй хамтран 2024 оны элсэлтийн ерөнхий шалгалтын материалыг орон даяар хүргэх ажлыг зохион байгууллаа.

## САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ



| ҮЗҮҮЛЭЛТ                     | 2023.Q2      | 2024.Q2      |
|------------------------------|--------------|--------------|
| Хаалтын ханш                 | ₮919         | ₮600         |
| Дээд болон доод үнэ          | ₮657 - ₮969  | ₮597 - ₮849  |
| Нийт арилжааны дүн           | ₮657.5.0 сая | ₮353.4 сая   |
| Зах зээлийн үнэлгээ          | ₮91.5 тэрбум | ₮59.7 тэрбум |
| Арилжаалагдсан хувьцааны тоо | 824,838      | 526,662      |
| ҮЗҮҮЛЭЛТ                     | 2023.Q2      | 2024.Q2      |
| EPS (TTM)                    | ₮4.8         | ₮0.2         |
| P/E (TTM)                    | 191.0x       | 2,653.0x     |
| P/B                          | 9.2x         | 6.0x         |

## САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ




## САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

| №  | ҮЗҮҮЛЭЛТ                                   | 2022Q2         | 2023Q2         | 2024          |              | Өөрчлөлт<br>2023Q2 / 2024Q2 |
|----|--|----------------|----------------|---------------|--------------|-----------------------------|
|    |  |                |                | I улирал      | II улирал    |                             |
| 1  | Борлуулалтын орлого (Цэвэр)                | 8,978.1        | 9,559.8        | 4,932.4       | 11,614.9     | 121%                        |
| 2  | Борлуулалтын өртөг                         | 9,266.8        | 10,527.8       | 4,958.6       | 10,652.5     | 101%                        |
| 3  | <b>Нийт ашиг</b>                           | <b>(288.7)</b> | <b>(967.9)</b> | <b>(26.2)</b> | <b>972.4</b> | <b>200%</b>                 |
| 4  | Түрээсийн орлого                           | 56.2           | 71.3           | 32.9          | 87.2         | 120%                        |
| 5  | Хүүний орлого                              | 193.2          | 211.7          | 97.6          | 176.2        | 83%                         |
| 6  | Ерөнхий удирдлагын зардал                  | 572.4          | 763.6          | 374.3         | 794.6        | 104%                        |
| 7  | Бусад зардал                               | 42.4           | 43.8           | 43.5          | 98.1         | 224%                        |
| 8  | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | 738.9          | 1,997.3        | -242.0        | -304.2       | -                           |
| 9  | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | -              | 4.0            | 0             | 1.0          | -                           |
| 10 | Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)      | 84.8           | 508.9          | -555.7        | 39.9         | 8%                          |
| 11 | Орлогын татварын зардал                    | 19.3           | 28.7           | 9.8           | 17.4         | 61%                         |
| 12 | <b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b> | <b>65.5</b>    | <b>480.2</b>   | <b>-565.5</b> | <b>22.5</b>  | <b>5%</b>                   |

## САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

| № | ҮЗҮҮЛЭЛТ                                   | 2023Q4         | 2024 ТӨЛ    | 2024Q2      |             | 2024<br>БИЕЛЭЛТ<br>Төл / Гүйц |
|---|--|----------------|-------------|-------------|-------------|-------------------------------|
|   |  |                |             | ТӨЛ         | ГҮЙЦ        |                               |
| 1 | Нийт орлого                                | 25,397.9       | 23,750.0    | 11,530.0    | 11,575.1    | 100.4%                        |
| 2 | Нийт зардал                                | 23,289.9       | 23,700.0    | 11,441.4    | 11,535.3    | 100.8%                        |
| 3 | Татварын өмнөх ашиг                        | 2,108.0        | 50.0        | 88.6        | 39.9        | 45%                           |
| 4 | Орлогын татварын зардал                    | 140.1          | 5.0         | 8.9         | 17.4        | 195%                          |
| 5 | <b>Тайлант үеийн ЦЭВЭР АШИГ (алдагдал)</b> | <b>1,967.9</b> | <b>45.0</b> | <b>79.7</b> | <b>22.5</b> | <b>28.2%</b>                  |

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

|   |  |
|---|--|
| <p>Овог, нэр: Г.Тэлмэн<br/>Албан тушаал: “Монгол шуудан” ХК<br/>Гүйцэтгэх захирал<br/>Гарын үсэг: .....<br/>(Тамга, тэмдэг)</p>  | <p>Овог, нэр: Г.Ганчимэг<br/>Албан тушаал: “Монгол шуудан” ХК<br/>Ерөнхий нягтлан бодогч<br/>Гарын үсэг: .....<br/>(Тамга, тэмдэг)</p> |
|---|--|

Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

|   |
|---|
| <p>Овог, нэр: Д.Цэцгээ<br/>Албан тушаал: “Монгол шуудан” ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга<br/>Гарын үсэг: .....<br/>Огноо:</p> |
|---|